



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАРХОРИН СУМЫН "ЭНЭРЭЛ ХАРХОРИН" НӨХӨРЛӨЛИЙН  
2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: ӨВА-2026/16/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өвөрхангай аймаг,  
Арвайхээр сум  
2026 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр

Утас: 70323108 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 143

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Энэрэл Хархорин” нөхөрлөлийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Энэрэл Хархорин” нөхөрлөлийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон зүйл

“Энэрэл Хархорин” нөхөрлөлийн үйл ажиллагааны зардлыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу нэг иргэнээр тооцсон төлбөрийн санхүүжилт 656,592.6 мянган төгрөг, 4 төрөлт тусламж үйлчилгээний санхүүжилт 207,735.0 мянган төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нэг иргэнээр тооцсон санхүүжилт 626,137.8 мянган төгрөг, 4 төрөлт тусламж үйлчилгээний санхүүжилт 247,121.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төвлөрүүлж, нийт 1,020,232.4 мянган төгрөгийг зарцуулж 141,181.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээллийн талаар онцлог анхаарал татсан зүйлгүй байна

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barim\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	257,288,222.18	174,962,345.85
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	257,288,222.18	174,962,345.85
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	62,984,750.28	41,701,657.27
1.1.2	Дансны авлага	60,727,574.82	11,236,516.50
1.1.6	Бараа материал	133,575,897.08	122,024,172.08
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	257,288,222.18	174,962,345.85
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	137,453,205.81	113,060,157.51
1.2.1	Үндсэн хөрөнгө	136,665,705.81	112,542,657.51
1.2.2	Биет бус хөрөнгө	787,500.00	517,500.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	137,453,205.81	113,060,157.51
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	393,953,927.99	287,505,003.36
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	112,486,749.45	147,234,498.32
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>112,486,749.45</b>	<b>147,234,498.32</b>
2.1.1	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>112,486,749.45</b>	<b>147,234,498.32</b>
2.1.1.1	Дансны өглөг	96,344,000.00	147,151,466.00
2.1.1.3	Татварын өр	16,142,749.45	-
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	83,032.32
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	112,486,749.45	147,234,498.32
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	112,486,749.45	147,234,498.32
	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	36,453,555.00	36,453,555.00
2.3	<b>Өмч</b>	36,453,555.00	36,453,555.00
2.3.1	-төрийн	36,453,555.00	36,453,555.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	245,013,623.54	103,816,950.04
2.3.10	Тайлант үеийн ашиг	-	(141,181,490.28)
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	393,953,927.99	287,505,003.36

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	889,330,473.80
8	Бусад орлого	-	3,499,100.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	947,816,426.31
11	Санхүүгийн зардал	-	158,546.00
12	Бусад зардал	-	86,051,274.99
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	-	(141,196,673.50)
20	<b>Татварын дараахь ашиг (алдагдал)</b>	-	(141,196,673.50)
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	-	(141,196,673.50)
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	36,453,555.0	0.0	0.0	-	0.0	0.0	188,094,893.03	224,548,448.03
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	38,988,964.6	38,988,964.60
2	Залруулсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	227,083,857.6	227,083,857.63
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	17,929,765.9	17,929,765.91
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	36,453,555.0	0.0	0.0	-	0.0	0.0	245,013,623.54	281,467,178.54
9	2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	36,453,555.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	245,013,623.5	281,467,178.54
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
11	Залруулсан үлдэгдэл	36,453,555.0	0.0	0.0	-	0.0	0.0	245,013,623.5	281,467,178.50
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	(141,196,673.50)	(141,196,673.50)
17	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	36,453,555.0	0.0	0.0	-	0.0	0.0	103,816,950.0	140,270,505.04

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.0	-
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	0.0	938,533,333.30
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.0	938,503,333.30
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.0	30,000.00
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	0.0	947,816,426.31
1.2.1	Ажиллагчдад төлсөн	0.0	635,799,238.45
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0.0	73,849,948.08
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	0.0	22,446,448.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.0	13,040,734.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	0.0	161,726.00

1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.0	89,100.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	0.0	202,429,231.78
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	0.0	(9,283,093.01)
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	0.0	12,000,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	12,000,000.00
4.1	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	0.0	(21,283,093.01)
5	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	0.0	62,984,750.28
6	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	0.0	41,701,657.27

### 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 59,704.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч, 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй байна.

#### 3.2 Албан шаардлага

1. Балансын урамшууллыг хууль эрх зүйн үндэслэлгүйгээр олгосон нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

2. Худалдан авах ажиллагааны тухай хуулийг зөрчин 51,870.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг тендер зохион байгуулаагүй шууд худалдан авсан байна.

#### 3.3 Зөвлөмж

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Нярав бараа материалын тайланг гаргахдаа зарим анхан шатны баримтыг батлагдсан маягтаар хөтөлж бүртгээгүй ( орлого, зарлагын баримт, жолоочийн тооцооны хуудас) , бараа материалын (нярвын) тайлангийн үлдэгдэл нь бараа материалын дэлгэрэнгүй болон тодруулга тайлангийн мэдээлэлтэй зөрсөн.

**Өгсөн зөвлөмж:** Бараа материалын орлого, зарлагын баримт, жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу бүрэн, үнэн зөв хөтөлж бүртгэх, бараа материалын (нярвын) тайлангийн үлдэгдлийг сар бүр дэлгэрэнгүй болон тодруулга тайлантай тулган баталгаажуулж, зөрүүг тухай бүр залруулан дотоод хяналтыг сайжруулах.

Энэрэл Хархорин Нөхөрлөлийн 2025 оны санхүүгийн тайланд **Өөрчлөлтгүй** санал дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн	0	0	0	0	0	0	0	0	00	00	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Түлээ нүүрсний хөнгөлөлтөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй байна.	1	1,137.6	1	1,137.6									
Нярав бараа материалын тайланг гаргахдаа зарим анхан шатны баримтыг батлагдсан маягтаар хөтөлж бүртгээгүй	1	3,723.4					1	3,723.4					
Балансын урамшууллыг хууль эрх зүйн үндэслэлгүйгээр олгосон нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	2,973.0			1	2,973.0							
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>7,834.0</b>	<b>1</b>	<b>1,137.6</b>	<b>1</b>	<b>2,973.0</b>	<b>1</b>	<b>3,723.4</b>	<b>0</b>	<b>00</b>	<b>0</b>	<b>0</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны тухай хуулийг зөрчин 51,870.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан	1	51,870.3			1	51,870.3		

авах зардлыг тендер зохион байгуулаагүй шууд худалдан авсан байна.								
Дүн	1	51,870.3	00	00	1	51,870.3	00	0
Нийт дүн	4	59,704.3	1	1,137.6	2	54,843.3	1	3,723.4

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН 13

6217143981  
ИНОА0059 9044094